



ӨЛЗИЙТИЙН МАЖИГ

Улаанбаатар хотын захиргааны дарга
1940-1941 он

Дарьгангын хошуу одоогийн Сүхбаатар аймгийн Онгон сумын нутагт малчин ардын гэрт 1910 онд төржээ. Багадаа гэрээр монгол бичиг сурчээ.

1926 оноос хязгаарын цэрэгт тал бичээчээр ажиллаж, МАХН-ын гишүүнд 1929 онд элссэн. 1929-1938 онд Дорнод аймагт аймгийн шүүхийн нарийн бичгийн дарга, шүүхийн дарга, аймгийн прокурор, аймгийн намын хороонд зохиолын хэлтсийн эрхлэгч, 1938-1940 онд Сэлэнгэ аймгийн хоршоодын холбооны даргаар ажиллаж байв.

1940 оны тавдугаар сард Улаанбаатар хотын дөрөвдүгээр их хурлаас хотын захиргааны даргаар сонгогдон, 1941 оны дол дугаар сар хүртэл ажиллажээ.

1941-1950 онд Хоршоодын төв холбооны дарга, БНМАУ-ын Ерөнхий сайдын орлогч, Худалдааны яамны сайдаар ажиллаж байгаад 1950-1953 онд Намын дээд сургуульд суралцаж төгссөн. 1953-1955 онд Сэлэнгэ аймгийн хөдөлмөрчдийн депутатын хурлын гүйцэтгэх захиргааны дарга, дараа нь БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн Хэрэг эрхлэх газарт нууцын эрхлэгчээр ажиллаж байгаад 1968 онд өндөр

насныхаа тэтгэвэрт гарчээ.

1944, 1945 онд Монголын ард түмнээс Зөвлөлтийн улаан армид өгсөн бэлгийн зүйлийг хүргэж гардуулах ажлаар хоёр ч удаа ЗХУ-д явсан байна.

Ө.Мажигийн хөдөлмөр бүтээлийг үнэлж “Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одон”, “Алтан гадас” одон, ойн медалиудаар шагнажээ.

1940 онд хуралдсан БНМАУ-ын VIII их хуралд Улаанбаатар хотоос төлөөлөгчөөр оролцож, бага хурлын гишүүнээр сонгогдсон байна. Энэ үед МАХН-ын X их хурлын шийдвэрийг хэрэгжүүлэх, нийслэл Улаанбаатар хотыг тохижуулан шинээр барилга барих, гудамж талбайг өргөтгөх, телефон утас, цахилгаан гэрлийн шугамыг нэмэгдүүлэх, хүн амын соёл боловсролыг ахиулах, эрүүл мэндийг хамгаалах талаар онцлон анхаарч, хот даяар эрчимтэй ажил зохиож байжээ. Нийслэл хотод сургууль, соёлын газрууд нэмэгдэн нийт хүн амыг бичиг үсэгт сургах ажил ихээр өрнөсөн юм. Тэр үед Улаанбаатар хот есөн хороо, 190 хоринд хамрагдаж байжээ. 1940 онд хотын нэгдүгээр дунд сургууль, таван бага сургуульд 1500, гурван цэцэрлэгт 95 хүүхэд хамрагдаж байв. Хүн эмнэлгийн амбулатори зургаа, бага эмчийн салбар тав, ариун цэврийн тасаг нэг ажиллаж байсан аж.

Улс орны батлан хамгаалах ажил онц чухлаар тавигдан, уг үйл хэрэгт зориулан хонжворт сугалаа гаргах, цэргийн албан хаагчдын ар гэрийг албан татвараас чөлөөлөх, тэтгэвэр тусламж олгож байв. Улсын худалдааны хөгжлийн тулгийн чулууг нийслэл хотод тавьснаар том жижиг 77 дэлгүүр ажиллаж, 29.0 сая төгрөгийн бараа гүйлгээ хийж байсан.

Ийнхүү дөчөөд он бол Улаанбаатар хотын түүх, хөгжил цэцэглэлтэд ихээхэн өвөрмөц өөрчлөлт гарсан үе болж түүхэнд үлджээ.

